



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудит тайлан

Аудитын код: СБА-2022/33/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт 2022 он	Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
	Утас: 70518369 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
	Аудитын менежер: Г.Даваа
	Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
	Аудитор: Б.Мөнхбамбар
	Утас: 70512127 Цахим хаяг: Munkhbambarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
Байгууллагын үйл ажиллагаа.....	8
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
3.6 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.7 Аудитын гол асуудал	9
3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
4. Аудитын илрүүлэлт	10
4.1 Албан шаардлага	10
4.2 Зөвлөмж	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт

1.Аудитын санал дүгнэлт
**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.03.05 № 104
танай _____-ны № _____-Т

АМГАЛАНТ ДЭНЖ УТҮГ-ЫН ДАРГА
Г.ИДЭРМӨНХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Амгалант дэнж УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Амгалант дэнж УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

				/төгрөгөөр/
Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Данс ны код	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
А	Б		1	2
1	ХӨРӨНГӨ		*	*
1.1	Эргэлтийн хөрөнгө		*	*
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		0.00	83,050.11
1.1.1.2	Банкин дахь мөнгө	1101	0.00	83,050.11
1.1.4	Бусад авлага		0.00	1,667,684.40
1.1.4.1	Хувь хүнээс авах авлага	1201	0.00	510,684.40
1.1.4.2	Байгууллагаас авах авлага	1202	0.00	1,157,000.00
1.1.6	Бараа материал		0.00	12,610,369.00
1.1.6.4	Хангамжын материал	1501	0.00	12,610,369.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн		0.00	14,361,103.51
1.2	Эргэлтийн бус хөрөнгө			
1.2.1	Үндсэн хөрөнгө		0.00	185,939,967.58
1.2.1.2	Барилга байгууламж	2001	0.00	196,125,584.86
1.2.1.3	Хуримтлагдсан элэгдэл. Барилга	2011	0.00	-22,891,969.94
1.2.1.4	Машин, тоног төхөөрөмж	2002	0.00	19,739,690.00
1.2.1.5	Хуримтлагдсан элэгдэл. МТТ	2012	0.00	-19,445,468.43
1.2.1.6	Тээврийн хэрэгсэл	2003	0.00	37,000,000.00
1.2.1.7	Хуримтлагдсан элэгдэл. Тээвэр	2013	0.00	-37,000,000.00
1.2.1.8	Тавилга эд хогшил	2004	0.00	40,896,203.00
1.2.1.9	Хуримтлагдсан элэгдэл. ТЭХ	2014	0.00	-31,870,921.91
1.2.1.10	Компьютер, бусад хэрэгсэл	2005	0.00	4,625,900.00
1.2.1.11	Хуримтлагдсан элэгдэл. Компьютер	2015	0.00	-1,239,050.00
1.2.1.12	Бусад үндсэн хөрөнгө	2006	0.00	1,483,330.00
1.2.1.13	Хуримтлагдсан элэгдэл. БҮХ	2016	0.00	-1,483,330.00
1.2.2	Биет бус хөрөнгө		0.00	90,000,000.00
1.2.2.13	Бусад биет бус хөрөнгө	2107	0.00	90,000,000.00
1.2.1	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		0.00	275,939,967.58
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		0.00	290,301,071.09
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
2.1	ӨР ТӨЛБӨР			
2.1.1	Богино хугацаат өр төлбөр			
2.1.1.3	Татварын өр		0.00	868,286.59
2.1.1.3.2	Орлогын татварын тооцоо		0.00	167,956.76
-	ААНОАТ тооцоо /ТТ-02 Нийтлэг/	1207	0.00	167,956.76
2.1.1.3.3	ХХОАТ-ын тооцоо /Суутган-1/	1208	0.00	700,329.83
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1210	0.00	3,372,209.85
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3206	0.00	270,008,845.36
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		0.00	274,249,341.80
2.1.2	Урт хугацаат өр төлбөр			
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн		0.00	274,249,341.80
2.3	2. Эзэмшигчийн өмч			
2.3.9	Хуримтлагдсан ашиг:		0.00	16,051,729.29
2.3.9.1	Тайлант үеийн ашиг	4112	0.00	16,051,729.29
2.3.11	Эздийн өмчийн дүн		0.00	16,051,729.29
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		0.00	290,301,071.09

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт		/төгрөгөөр/	
			2020 ОНЫ 12 САРЫН 31	2021 ОНЫ 12 САРЫН 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		0.00	81,277,000.00
1.1	Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	5101		80,870,000.00
1.2	Ажил үйлчилгээ борлуулсны орлого	5102		1,007,000.00
1.3	Борлуулалтын буцаалт	5201		-600,000.00
3	Нийт ашиг /алдагдал/			81,277,000.00
8	Бусад орлого			33,805,964.66
	Үйл ажиллагааны бус орлого	8403		25,225,964.66
	Санхүүжилтийн орлого	8406		8,580,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал			65,037,589.58
-	Ажиллагчдын цалингийн зардал	7001		21,475,289.87
-	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	7002		2,891,107.11
-	Шуудан холбооны зардал	7006		49,900.00
-	Ашиглалтын зардал	7011		7,729,654.60
-	Шатахууны зардал	7018		1,489,548.00
-	Бусад зардал	7021		31,402,090.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал			33,749,699.02
-	Ажиллагчдын цалингийн зардал	7001		13,956,520.00
-	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	7002		1,777,156.86
-	Томилолтын зардал	7004		192,000.00
-	Бичиг хэргийн зардал	7005		725,300.00
-	Шуудан холбооны зардал	7006		49,900.00
-	Сургалтын зардал	7008		330,000.00
-	Ашиглалтын зардал	7011		1,317,300.72
-	Элэгдэл, хорогдлын зардал	7013		11,958,773.44
-	Шатахууны зардал	7018		1,565,148.00
-	Бусад зардал	7021		1,877,600.00
12	Бусад зардал /ҮАБЗ/			575,990.00
-	Торгууль алдангийн зардал	8702		45,000.00
-	Үйл ажиллагааны бус зардал	8705		530,990.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			500,000.00
-	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	8410		500,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)			16,219,686.05
19	Орлогын татварын зардал			167,956.76
-	Тайлангийн үеийн орлогын татварын зардал	9101		167,956.76
20	Татварын дараах ашиг (алдагдал)			16,051,729.29
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/			16,051,729.29
24	Орлогын нийт дүн			16,051,729.29
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/			

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1									
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								0.00
3	Залруулсан үлдэгдэл								0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг								0.00
5	Бусад дэлгэрэнгүй орлого								0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт								0.00
7	Зарласан ногдол ашиг								0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								0.00
9	2020 оны 12 сарын 31 үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/							16,051,729.29	16,051,729.29
13	Бусад дэлгэрэнгүй орлого				0.00	0.00	0.00		0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00	0.00		0.00
15	Зарласан ногдол ашиг							0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				0.00				0.00
17	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	16,051,729.29	16,051,729.29

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөр дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	0.00	88,700,000.00
	1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		80,120,000.00
	1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого		8,580,000.00
1.2	<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	0.00	85,484,049.89
	1.2.1 Ажилчдад төлсөн		29,298,350.48
	1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		5,400,000.00
	1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн		31,245,990.00
	1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн		9,046,955.32
	1.2.5 Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		3,054,696.00
	1.2.7 Татварын байгууллагад төлсөн		1,339,868.09
	1.2.8 Бусад мөнгөн зарлага		6,098,190.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	3,215,950.11
2.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	0.00	3,500,000.00
	2.1.1 Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		500,000.00
	2.1.5 Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		3,000,000.00
2.2	<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	0.00	6,652,900.00
	2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		3,152,900.00
	2.2.5 Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		3,500,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	-3,152,900.00
3.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	0.00	20,000.00
	3.1.1 Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		20,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	20,000.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	83,050.11
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	83,050.11

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Амгалант дэнж УТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данс, дотоод хяналт, тээвэр шатахууны зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 1 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ статустайгаар төрийн 100 хувийн өмчлөлтэй, аймгийн Засаг даргад харьяалагдаж, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

 Иргэдэд амралт, сувиллын чиглэлээр үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 99.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 0.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ийн зорилго нь Монгол Улсын болон гадаад улсын иргэдийн амрах нөхцөл боломжийг бүрдүүлсэн, амралтын үйл ажиллагааны эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан үйл ажиллагааны тогтвортой, найдвартай, хүртээмжтэй, тасралтгүй байдлаар хангахад зорилт оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авто зам, засвар арчлалт гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Иргэдэд амралт, сувиллын чиглэлээр үйлчилгээ үзүүлэх чиглэлтэй байна. Өмчийн 100 хувь орон нутгийн эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Аймгийн ИТХ-ын 2021 оны 27 дугаар тогтоолоор Амгалант Дэнж УТҮГ нэртэйгээр байгуулагдаж 2021 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс үйл ажиллагаа эхэлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй: ... 5/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих;...” гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй боловч чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоогоор 15 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулахаас 4 орон тоотой явуулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 0.8 сая төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0.08	0.08
Авлага	-	1.7	1.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	-	12.6	12.6
Үндсэн хөрөнгө	-	185.9	185.9
Биет бус хөрөнгө	-	90.0	90.0
Нийт хөрөнгийн дүн	-	290.3	290.3
Өр төлбөрийн дүн	-	274.2	274.2
Богино хугацаат өглөг	-	274.2	274.2
Урт хугацаат өглөг	-	-	-
Эздийн өмч	-	16.1	16.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	290.3	290.3

Бараа материалын дансны үлдэгдэл 12.6 сая төгрөг байгаа нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 31 дүгээр тогтоолоор шилжиж ирсэн хөрөнгийг бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 185.9 сая төгрөг байгаа нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 31 дүгээр тогтоолоор шилжиж ирсэн хөрөнгийг бүртгэсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 274.2 сая төгрөгийн байгаа нь үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал тайлант онд 99.4 сая төгрөгөөр илэрхийлсэн байна.

3.6 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.7 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 103 мэдээллээс хугацаандаа оруулсан 81 мэдээлэл, хугацаа хоцорч 21 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ын тайлант оны үйл ажиллагаа, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудалгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4 алдаа зөрчил илэрснээс, 1 алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 асуудалд зөвлөмж өгсөн.

4.1 АЛБАН ШААРДЛАГА

Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг нүд үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж, баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 /эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;/, 72.4.2/ тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;/, 72.4.4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/ дахь заалт болон иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн сайтад тайлант хугацаанд оруулах мэдээллээс 21 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

1.1. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Байгууллагын өмч хөрөнгө, төсвийн санхүүгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Дээд шатны байгууллага болон эрх бүхий этгээд дотоод хяналтын журмыг батлаагүй бол Засгийн газрын 2011 оны “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тушаалын дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журмыг баталж, өмч хөрөнгө, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх

3. Тээвэр шатахууны зардалтай холбоотой

3.1 Илрүүлэлт

Тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох арга зүй, стандартын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй зөрчил дутагдал илэрсэн. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал заалтуудыг тус тус зөрчжээ.

3.2 Өгсөн зөвлөмж

Тээвэр шатахууны зардлыг зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, замын хуудсыг тодорхой бичиж, зардлыг бууруулах арга хэмжээ авах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/сая төгрөгөөр/									
		Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Амгалант дэнж УТҮГ	4	-	-	-	-	-	1	-	3	-
Дүн		4	-	-	-	-	-	1	-	3	-